



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 05 сарын 25 өдөр

Дугаар А/287

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай Монгол Улсын хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Эх үрсийн баярыг тохиолдуулан зорилтот бүлгийн манлайлагч ээжүүдэд хүндэтгэл үзүүлэх арга хэмжээний зардал 5 000 000 төгрөгийг хавсралтын дагуу зарцуулсугай.

2.Дээрх арга хэмжээнд шаардагдах 5 000 000 төгрөг /таван сая/-ийг орон нутгийн хөгжлийн сангийн төсөл, арга хэмжээний 5.26-д тусгагдсан “Зорилтот өрхийн хөгжил хамгааллыг сайжруулах” аймгийн дэд хөтөлбөрийн зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн дарга /Б.Даваадорж/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА




Б.ДҮГЭРЖАВ

Zax A/287-Ch

02 01246

Аймгийн Засаг даргын 2020 оны
05 дугаар сарын 26-ны өдрийн
А/287 дугаар захирамжийн хавсралт



МАНЛАЙЛАГЧ ЭЭЖҮҮДЭД ХҮНДЭТГЭЛ
ҮЗҮҮЛЭХ ЗАРДЛЫН ТӨСӨВ

№	Үйл ажиллагааны зардал	Тоо ширхэг	Нэгж үнэ /төг/	Нийт/төг/
1	Хүндэтгэлийн идээ, гарын бэлэг, дурсгалын зүйл	48	100000	4 800 000
2	Бусад зардал			200 000
	НИЙТ			5 000 000

-oOo-